

БӨӨРНИЙ ӨВЧНИЙ ТУХАЙ ЭХ СУРВАЛЖИЙН СУДАЛГААГ.Гүнжидмаа¹, А.Нарханд², С.Халиунаа³, Б.Оюун-Эрдэнэ⁴, Х.Туул⁵^{1,2} Эрдмийн сургууль, Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль^{3,4} УАУ 201, Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль⁵ УАУСТ, Эм Зүйн Шинжлэх Ухааны Их СургуульЦахим хаяг: tuul.kh@monos.mn Утас: 99795290**RESEARCH ON KIDNEY DISEASE IN THE SCRIPTURES**Gunjidmaa G¹, Narkhand A², Khaliunaa S³, Oyun-Erdene B⁴, Tuul Kh.⁵tuul.kh@monos.mn**Abstract**

Introduction: Kidney disease is common in our country due to the four seasons and harsh climate. This article is discussed about the kidney health, causes, pathology and kidney on the relationship of other organs in traditional medicine.

Methods: The study was processed using analysis and synthesis methods.

Results:

1. The root nature of the five vital organs are included in the yang character organs which hot nature qualities in five elements. However, some of the five vital organs will be under the influence of that place, as they will be located in the place of the “badgan”, in the place of the “mkhris”, and in the place of the “rlung”.

2. Kidney disease is usually caused by falling from a height, hit and injured, lifting heavy things, jogging and twisting your back uncomfortably, sit for a long time in a damp place, water events excess, eating too sweets that are heavy and cold qualities. In medical practice, kidney disease is accompanied by heart disease and liver disease.

Conclusion:

In according to traditional medicine main theory, kidneys are a solid vital organ that generates heat and warms the lower body because of the high blood flow through its, on the other hand they are cold character which are in the place of the “rlung”. The kidneys are functionally closely related to other organs therefore, to get sick the effects of disease on other organs.

Key words: the kidney health in traditional medicine, the kidney pathology in traditional medicine

Үндэслэл:

Манай орон жилийн дөрвөн улиралтай, эрс тэс уур амьсгалтай учраас бөөрний өвчлөл түгээмэл байна. Хүн амын өвчлөлийн дөрөвдүгээр шалтгаан болсон шээс бэлгийн тогтолцооны өвчин сүүлийн 10 жилийн

дунджаар нийт өвчлөлийн 10.6 хувийг эзэлж байна. Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл (10000 хүн амд ногдох) 2020 онд 1084 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 188-аар илүү, өмнөх оноос 36-аар буурсан байна. Харин шээс бэлгийн тогтолцооны өвчний түвшинг

2020 оны байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 560 болж, 10 жилийн дундажаас 140-өөр, эмэгтэйчүүдийнх 1594 болж, 10 жилийн дундажаас 263-аар тус тус илүү байна ¹. Уламжлалт анагаах ухаанаар бөөр нь усан махбодтой доод биед оршдог хүний биеийн усны үйл ажиллагааг зохицуулдаг эрхтэн юм. Уламжлалт анагаах ухаанд бөөрний өвчнийг 8 ангилж, бөөрний махбодийн мөн чанартай нь зохицсон эм заслаар бөөрний өвчнийг үр дүнтэй эмчилж ирсэн туршлагатай. Тус өгүүлэлд уламжлалт анагаах ухааны бөөрний эрүүл зүй, өвчний шалтгаан ба өвчин зүйг судар номоос түүвэрлэн нэгтгэх зорилго тавьж, бөөр болон бусад цул сав эрхтэний холбоо хамаарлын тухай тодруулсанаар эмнэлзүйн практикт бөөрний өвчлөлийг оношилж эмчлэхэд удирдамж болгох боломжийг эрэлхийлж тус өгүүлийг эмхэтгэв.

Судалгааны материал, арга зүй:

Судалгаанд дараах судар номыг ашиглав. Үүнд: 1/ Ютиг Ёндонгомбо. Анагаах ухааны дөрвөн үндэс 2/ Бэй Бой Юу. Бие махбодийн сургаал 3/Дэсрид Санжаажамц. Лхантав. Бөөрний өвчнийг анагаах 61-р бүлэг 3/ Ишбалжир. Дөрвөн рашааны Рашааны цагаан шүүдэр 4/ Жамбалчойжиданзанпэрэнлэй. Увдисын далай судар номыг ашигласан болно. Судалгааг эх бичиг, сурвалж судлалын харьцуулах аргаар бөөрний эрүүл зүй, өвчний шалтгааныг судалж, магадлан жагсаах аргаар бөөрний өвчний өвчин зүй, бөөр болон бусад эрхтэний хоорондын хамаарлын онцлогийг тодрууллаа.

Судалгааны үр дүн: 1. Уламжлалт анагаах ухаан дахь бөөрний эрүүл зүй

Бөөр бол нурууны ясны 14-р үений зүүн баруун талд тус тус өргөнөөрөө 7 хуруу, уртаараа 5 хуруу хэмжээнд хэвлийн хөндийн ар хананд наалдан байгаа хос цул юм².

Бөөрний гадар дүрс нь буурцгийн хэлбэртэй байдаг. Онолын үндэст “бөөр нь гадаад түшмэл буюу бүх нуруугаа үүрсэн мэт”^{3,4} гэж үлгэрлэн тэмдэглэснээс үзвэл бөөр бол “хаан цул” зүрхнээс доод хэсэгт томилогдсон гадаад түшмэл мэт цул ажээ. Бөөр бол цул эрхтэн тул зүрх зэрэг бусад цултай адилаар аргын хэмжээнд багтаж, аргын чанартай бүлээтгэх үйлдэлтэй эрхтэн болно.

Таван цул яагаад аргын чанартай байдаг вэ гэвэл ром судал нь цусны судлаас эхэлсэн арга судал² болохоор таван цулыг төлжүүлж, цусыг боловсруулах, хангах, цэвэршүүлэх ажиллагааг гүйцэтгэж байдаг. Энэ нь одоо үеийн анагаах ухааны элэг бол цусыг хадгалж, цөсийг боловсруулдаг, зүрх бол цусыг бүх биед хангадаг, уушиг бол цусыг хийжүүлдэг, дэлүү бол цусыг цэвэршүүлдэг, бөөр бол цусны шүүлтийн үйлийг гүйцэтгэдэгтэй нийцэж байгаа юм. Иймээс таван цулын язгуур мөн чанар нь цус, шар буюу халуун мөн чанартай аргын хэмжээнд багтана. Гэвч таван цулын зарим нь бадганы оронд, зарим нь шарын оронд, зарим нь хийн оронд байрладаг тул тэрхүү орны нөлөөнд байдаг. Бөөр бол маш олон нарийн цусны судлаар торлож бүтсэн бөгөөд бөөрний үүдэн судлаар гүйсэн цус нь амин судалтай шууд холбогдоно. Бөөр цуснаас шээсийг ялгах үйл ажиллагааг гүйцэтгэж ялгарсан шээс нь шээсний цоргоор дамжигдан давсагт ордог. Иймээс бөөр нь илүү цус дийлэнхүй байдаг тул халуун чанартай цул болно.

Бөөр бол гэдэс, олгой, хошноого, давсаг, самс, хүүхэн хэвтэш зэрэг эрхтнүүдтэй хамт хэвлийн доод хэсэгт байрлаж байдаг. Уламжлалт анагаах ухаанд хүний биеийн доод хэсгийг хийн ерөнхий орших орон бас бадган хүйтний орон гэдэг. Бөөр нь биеийн доод хэсгийн хийн оронд оршдог³ учраас хүйтэн чанартай гэж үзэж болох ч дээр өгүүлсэнээр

аргын хэмжээнд багтах халуун чанартай цул бөгөөд бадган хүйтний оронд “гадаад түшмэл” мэт томилогдон давсаг, самс зэрэг эрхтнүүдийг хамааран захирч, дулаалцуулах, илчийг олгож, үйл ажиллагаанд нь гол хүч болдог байна.

2. Уламжлалт анагаах ухаан дахь бөөрний өвчний шалтгаан ба өвчний зүй

Бөөрний өвчин бол голдуу өндөр дээрээс унаж доргих, цохигдож гэмтэх, хүнд юмыг өргөж, хатуу хүчлэн^{3,5-6} гүйж харайх ба нуруугаа эвгүй мушгих, нойтон чийгтэй газар удаан хугацаагаар суух, амтлаг идээний зүйлийг хэтэрхий идэх⁷⁻⁸ зэрэг дотоод шалтгаанаас өвчилдөг.

Бөөр бол аргын чанартай болохоор бүлээтгэх үйлдэлтэй бөгөөд илчтэй юм. Энэ нь бөөрний хуваарь галын илч³ мөн. Бөөрний илчийн суурь нь цусны тамир болно. Дээр дурьдсан бөөрний өвчнийг үүсгэх шалтгаан нөхцлүүд бол юуны өмнө галын илчийг алдуулах болохоор бөөрний илч нь дагалдан буурна. Бөөрний илч буурвал халуун хүйтэн хямарч эрүүл ажиллагаа нь алдагдаж бөөрний өвчний хувиралт үүснэ.

Эртний зохиолд “таван цул бол аргын чанартай, зургаан сав бол билгийн чанартай” гэдэг. Үүнээс бөөрийг аргад багтаах халуун чанартай цул гэж үзнэ. Бөөр хэдийгээр аргын чанартай боловч билгийн чанартай оронд барилдаж байгаагийн эрхээр халуун чанартай өвчин нь хүйтэн давамгай шинж тэмдэгтэй байдаг. “Хэрэгт дөрвөн товчоо”-ны бүлэгт “бөөр нь бадган хүйтний оронд байрлах тул халуун өвчин оршивч шээс чавдагшиж, даарвал өвчин хөдөлж хүйтний шинжийг үзүүлнэ” гэжээ³. Энэ нь нэг талаас бөөрийг аргын чанартай, нөгөөтэйгүүр бөөр өвчилбөл түүний шинж нь халуун хүйтэн аль талаар ч

илэрч болохыг илэрхийлжээ. “Дөрвөн үндэст”-т бөөрний өвчнийг 8 зүйлээр ялгасан боловч бодитойгоор олон зүйлийн өвчин байдаг. Жишээлбэл: бөөрний чулуушрал, шижин, усан хаван зэрэг бий. Ерөнхийлбөл бөөрний өвчин чанарын хувьд халуун, хүйтэнд багтана.

Хэлцэмж: Бөөр хэдийгээр цулын хувиар аргад багтах боловч, бусад галын махбодын цултай адилтгавал усан махбодын орон, бадганы гүйх мөр болдог тул илчийн хувь нь бусад цултай адилгүй бага юм⁵. Иймээс бөөрний өвчнийг оношлохдоо зөвхөн түүний бадган хийн орон ба махбодын орны онцлогоор хүйтэн гэж үзэн түүний аргад багтах халуун талыг орхигдуулж болохгүй. Учир нь эмчилгээ оношилгооны хувьд бөөрний эрүүл зүйг бодолцохгүйгээр бөөрний маш олон халуун чанар бүхий өвчнийг хүйтэн чанартай гэж эндүүрдэг байна. **Уламжлалт анагаах ухаанаар бөөр бусад эрхтэний холбоо хамаарлыг авч үзвэл эмнэлзүйд** бөөрний өвчинд зүрхний өвчин, элэгний өвчин зэрэг дагалдан үүсдэг. Дөрвөн үндэст ч “бөөрний судас гэмтсэн буюу элэгний цус цувирч шээстэй холилдосоноор цусаар шээнэ” гэж тэмдэглэсэн байдаг³. Энэ нь хар цагаан судлын шалтгаантай. Үүнд:

1-рт цусны судлын шалтгаан нь цус бол элэгнээс зүрхэнд орж, зүрхнээс амин судлаар дамжин бүх биед түгдэг. Бөөрний судал бол гол судлаас салаалан бөөрөнд орж, бөөрний оронд хий цусны эргэлт явагдана². Онолын үндэст “дотор судалд хар цагаан 2 зүйлийн амин судал буй бөгөөд нурууны дотуур босоо нарсан мод мэт орших болно. Түүнээс салаалан гарсан нарийн судлууд бүх биед салбарлана. Нурууны 9-р үеэс нэг судал гарч элгэнд, 11-р үеэс дэлүүнд, 13-р үеэс самсад, 14-р үеэс бөөрөнд тус тус барилдана”³⁻⁴ гэжээ. Энэ бол бөөрний цусны судлын эх ирэлт мөн. Үлгэрлэвээс цөөрмийн усны суваг адилаар

урсаж тарианд орохтой адилаар элэг, зүрх, болон бөөр бол цусны хувьд нэг системд багтах тул аль нэгэнд өвчин тусвал бусад нь дагалдан өвчилдөг.

2-рт цагаан судлын шалтгаан нь тархинаас гарч доош хатгасан хэвийн унжлагын шижим адил 13 цагаан судлаас бадганы 4 судлын нэг нь нурууны 14-р үеэс бөөрөнд барилддаг.²⁻⁴ Энэ бол цагаан судлын бөөрөнд хамаатай нэгэн салаа юм. Нөгөө нэг нь гадар судал бөгжин судал нь шилний хонхроос гарч хүзүүний анхдугаар үеийн зүүн баруун хажууд тус бүр нэг ямхын чигээр дамжиж, нурууны 12-р үеэс ходоод, дэлүүнд барилддаг. Бас нэг “эх уушиг”-ны хажуугаас гарсан судал нь 13-р үеийн чигт барилдах бөгөөд өрцнөөс дээш бол уушгийг, доош бол бөөрийг тус тус хамаардаг байна. 14-р үеийн чигт байгаа судлыг үндсэндээ “бөөрний хар судал” гэж нэрлэсэн ^{3,4} байна. Эдгээр гадар дотор судал нь бөөрөнд барилдаж, бөөрний эрүүл ажиллагааг захирна. Бие махбодийн цагаан судал, цусны судал нь харилцан хамааралтай тул өвчний үед ч дагалдан өвчилдөг. Учир нь хар судлаар цус гүйдэг бөгөөд цагаан судлаар хий гүйдэг, хий цусны эргэлтийн хэвийн байдал алдагдаж хувиралт үүсвэл бие махбодийн эрүүл ажиллагаа нь сулран алдагдаж бусад хэсгийг ч нөлөөлдөг. Бөөр нь уламжлалт анагаах ухаанаар цул эрхтэн бөгөөд цус гүйдэг учраас илчийг үүсгэж доод биеийг дулаацуулдаг. Гэвч бөөр нь бадган хийн оронд байрлаж усны үйлийг хийдэг цул мөн. Иймд бөөрний бүтэц, эрүүл зүйн мөн чанар нь аргын чанартай, орны үүднээс бөөрний үйл ажиллагаа нь билгийн чанартай эрхтэн тул бөөрний өвчлөлд халуун хүйтний шинж тэмдэг холилдон илрэх тул оношилгоо, эмчилгээнд өвчний мөн чанарыг баримтлах нь зүйтэй.

Ном зүй:

1. Эрүүл мэндийн үзүүлэлт. <http://hdc.gov.mn> сайтад хандсан 24/04/2022
2. Бой Юу Бэй. Бие махбодийн сургаал. ӨМАХХ, 1989, 29-39, 136-139, 240-247, 271, 387-399.
3. Ёндонгомбо Ютиг. Онолын үндсийн биеийн адил үлгэрийг үзүүлсэн 3-р бүлэг. Анагаах ухааны дөрвөн үндэс. Лианонин, ӨМТМХХ, 1987, 50-52, 351-356, 537-541.
4. Лувсанчойдог Дармаамаарамба. Хаан түшмэд, тэнгэр охин тэнгэр нар бүрэлдсэн мэтээр үлгэрлэн үзүүлсэн 3-р бүлэг. Алтан хадмал, ӨМАХХ, 1984, 85-92.
5. Санжаажамц Дэсрид. Бөөрний өвчнийг анагаах 61-р бүлэг. Лхантaв, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1988, 299-301.
6. Ишбалжир. Дөрвөн рашаан. Рашааны цагаан шүүдэр. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1998, 89-101.
7. Жамбалчойжиданзанпэрэнлэй. Эмэгтэйн өвчнийг засах тухай. Увдисын далай. Доод дэвтэр. Монгол түүх соёлын сонгодог зохиолын хөмрөг. Монгол анагаах ухааны тулгуур бичиг, Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, Хөх хот, 2014, 625.
8. Сүрэнжав Ц. Бөөрний өвчин. Монгол анагаах ухааны эмчилгээний судлал, Хөх хот 1999, 518-536.

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:

ЭЗУ-ы доктор, дэд профессор

Т.Ахтолхын